

ЗАСАГ ДАРГА БАТЛАВ: Б.СУГАР  
2019 он 07 сар 26 ны өдөр



НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

“АРИУТГАЛЫН ЯВУУЛЫН ПОСТ “ ХУДАЛДАН АВАХ  
ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ

2019- ОН

**НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Огноо: 2019.07.25

***“АРИУТГАЛЫН ЯВУУЛЫН ПОСТ”***  
**ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН БИЧИГ БАРИМТ**

**Төслийн нэр:** Ариутгалын явуулын пост

**Төслийн дугаар:** ӨВНТСЗДТГ/201901006

**Гэрээний дугаар:**0

### **Нэг. САНАЛ АВАХ УРИЛГА**

1. ***[Нарийнтээл сумын ЗДТГ]*** нь эрх бүхий тендерт оролцогчид /хуулийн этгээд, иргэн/-оос ***[Ариутгалын явуулын пост ]***-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.
2. Санал ирүүлэхэд шаардагдах материал ***[бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, зураг төсөл, гэх мэт]***-ыг хавсаргасан болно.
3. Саналыг ***[2019 оны 08 дугаар 01-ны өдрийн, 10 цаг]***-аас өмнө ***www.tender.gov.mn. цахим]*** хаягаар ирүүлнэ.
4. Саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан ***[2019 оны 08 дугаар сарын 01]***-ны өдрийн ***[10 цаг 30 минутад]***<sup>1</sup>-т нээнэ.

***[Захиалагчийн тодорхой хаяг:Нарийнтээл сумын ЗДТГазар  
(2 давахарт, С.Баасандулам 95259400, Ц.Сайнбилэг 88305094)]***

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
    - 1.1. Сангийн сайдын 2013 оны .... дугаар сарын .... –ны өдрийн ... дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдсан Иргэдийн бүлэг байна.
  2. Оролцогчийн чадвар
    - 2.1. Тендерт оролцогч дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх ба холбогдох мэдээллийг маягт 3-ийн дагуу саналд ирүүлнэ. Үүнд:
      - (а) **[Шаардлагатай мэдээллийг нөхөж оруулах]**
  3. Тендерийн иж бүрдэл
    - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараахь зүйлээс бүрдэнэ:
      - (а) Үнийн санал /үнийн хуваарь/;
      - (б) Чадварын мэдээлэл /маягт 3-ийн дагуу/;
      - (в) Бараа нийлүүлэлтийн болон ажил гүйцэтгэх үйл ажиллагааны хуваарь<sup>2</sup>
      - (г) Бусад баримт бичиг:

-бүлгийн гишүүдийн цахим үнэмлэхийн хуулбар,  
бүлэг байгуулсан шийдвэрүүдийг хавсаргасан байх.
    - 3.2. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
      - (а) [1. Үнийн саналын маягт]
      - (б) [3. Чадварын мэдээллийн маягт]
      - (в) [Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор бүх баримт бичгийг жагсаан бичих]
      - (г) ....
  4. Үнийн санал
    - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
    - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг үнийн саналд тусган санал ирүүлж болно.
    - 4.3. Тендерт оролцогч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
  5. Саналын хүчинтэй байх хугацаа
    - 5.1. Санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
  6. Алдааг
    - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг
-

## **залруулах**

шалгаж дараахь байдлаар залруулна:

### **6.2.**

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үнийн хуваарь болон ажлын хуваарьт тусгагдсан үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үнийн хуваарь, ажлын хуваарьт заасан үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;

6.3. Захиалагчийн залруулсан үнийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан.

## **7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Захиалагч хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзэж тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

## **8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

8.2. Бусад оролцогчдод тэдгээрийн шалгараагүй үндэслэлийг тодорхой тайлбарласан мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлнэ.

## Гурав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |  |
|--|--|
| 1. Гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээ        | 1.1. Гүйцэтгэгч [ <b>Ариутгалын явуулын пост</b> ]-г гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| 2. Ажлын хуваарь                           | 2.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөл буюу техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт заасан хуваарийг чанд мөрдөж ажиллана.  |
| 3. Оюуны өмчийн эрх                        | 3.1. Гэрээнд заагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаанд оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.   |
| 4. Гэрээнд өөрчлөлт оруулах                | 4.1. Гэрээний дагуу худалдан авах [ <b>Ариутгалын явуулын пост</b> ]-ны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 5. Гүйцэтгэлийн хянагч                     | 5.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий захиалагчийг төлөөлөн гүйцэтгэлийн хянагч ажиллана.  |
| 6. Төлбөр                                  | 6.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ <b>тоо</b> ] хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 7. Алданги оногдуулах                      | 7.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч [ <b>нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ</b> ]-ний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.   |
| 8. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 8.1. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 9. Маргааныг шийдвэрлэх                    | 9.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |
| 10. Бусад нөхцөл                           | 10.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаатай байна.<br>10.2. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.<br>10.3. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна. |

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- |                              |   |
|------------------------------|---|
| 11. Үйл ажиллагааны хөтөлбөр | 11.1. Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд гүйцэтгэлийн хянагчид хүргүүлж батлуулна. |
|------------------------------|---|

- |   |  |
|---|--|
| <b>12. Зөрчил, гологдол илрүүлэх</b>        | 12.1. Гүйтгэлийн хянагч гүйцэтгэгчийн үйл ажиллагааг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйтгэлийн хянагч нь гүйцэтгэж буй аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах эрхтэй.   |
| <b>13. Зөрчил, гологдол арилгах</b>         | 13.1. Гүйтгэлийн хянагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>3</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br><br>13.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| <b>14. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | 14.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол Гүйтгэлийн хянагч зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.  |

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- |   |   |
|---|---|
| <b>15. Гэрээний үүрэг дуусгавар болох</b> | 15.1. Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хэрэгжүүлж дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг гүйтгэлийн хянагчид хүргүүлэх бөгөөд гүйтгэлийн хянагч ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. |
|---|---|

## Дөрөв. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>4</sup>

**ГЕН 1.1** Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: [Ариутгалын явуулын пост, ӨВНТСЗДТГ/201901006]

Гэрээний үүрэг хэрэгжүүлэх газар нь **Нарийнтээл сумын 4 дүгээр баг “Цагаан-овоо”-д** байрших ба зураг № 01-д зааснаар тодорхойлогдсон болно.

**ГЕН 3.1** Гэрээ хэрэгжүүлж эхлэх өдөр 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

Гэрээг дуусгахаар төлөвлөсөн өдөр 2019 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр

**ГЕН 4.1** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.

**ГЕН 6.1** Чанарын баталгаат хугацаа эсхүл баталгаат засварын хугацаа 1 **хүртэл жил** байна.

**ГЕН 7.1** Гэрээний ерөнхий нөхцөлийн 6 дугаар зүйлийг дараахь байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:**[Захиалагч энэхүү гэрээний дагуу төлөх төлбөрийн хуваарийг нарийвчлан тусгаж өгнө.]**

**ГЕН 8.1** Алданги ногдуулах хэмжээ гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн \_\_\_хувь байна.<sup>5</sup>

Нийт ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн **[\_\_\_] хүртэл хувь** байна.

## Тав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- 1. Барааны тодорхойлолт:** [ Ариутгалын явуулын пост худалдан авах тендер, ажлын зураг төсөл, техникийн үзүүлэлтийг хүснэгтээр гаргаж хавсаргав.]
- 2. Стандарт:** Чанарын шаардлага хангасан материалаар хийгдсэн, техникийн тодорхойлолтонд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэж хүлээлгэж өгсөн байна.
- 3. Бараа хүргэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх газар:** [Нарийнтээл сумын ЗДТГазар, 4-р баг]
- 4. Үйл ажиллагааны хуваарь:**


### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУВААРЬ

№	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Тоо,	Гүйцэтгэх хуваарь <sup>6</sup> хойш /, долоо хоног,





### Техникийн тодорхойлолт

№	Иж бүрдэл/ төрөл	Тоо хэмжээ	Шалгуур үзүүлэлт
1	Ариутгалын явуулын постны өндөр, өргөн		өндөр - 2.20 м, өргөн-2,0 м, урт -3.5 м,
2	Цонх	3	Цонхны хэмжээ: 100х40 см хэмжээтэй 2 ш, 80х40см хэмжээтэй 1ш вакум цонх байх ба цонх тус бүр 40х40 хэмжээтэй салхивч /порчик/-тай байна
3	<b>Хаалга</b>	1	Бүргэд хаалгатай дүйцэхүйц төмөр хаалга байна. Хаалга нь бэхэлгээ, нугас сайтай, нууц цоожтой байна.
4	Дотор тал		Сип хавтантай дүйцэхүйц материалаар доторлоно. Энэ нь угааж цэвэрлэхэд хялбар, өнгө үзэмж сайтай байх. хөөсөөр дулаалга хийсэн байх.
5	Гадна тал		Гадна талыг өнгө үзэмж сайтай төмөр буюу сайтнк төмөртэй дүйцэхүйц материалаар хийсэн байна.
6	Дугуй	4	Дугуйны голч нь 14 буюу түүнээс дээш байх, дугуйны хүрд, тэнхлэгийн урт стандартын хэмжээтэй байх.
7	Дээвэр		Усны уналттай байх ба сайн чанарын зузаан төмрөөр хийгдсэн байна.
8	Шал		3 см-ын банзаар шаллаж паркетласан байна. Зуухны доод хэсэг галд тэсвэртэй материалаар хийгдсэн байна.
9	Зуух /пийшин/		Пийшинтэй байх ба яндан зуухыг суурилуулж хүлээлгэж өгнө. Зуухны дээд талд агааржуулалт хийсэн байх ба хана хэсгийг халаалтаас хамгаалсан байх.
10.	Амрах ор	2	2 м урттай, 90 см өргөнтэй байна. Ор нь давхар байна. Доод орыг хайрцаг хэлбэрээр битүү хийх ба эд зүйлсээ хадгалах зориулалтаар ашиглагдана. Дээд ор нь эвхддэг байх.
10	Ширээ	1	Эвхдэг ширээ 1 ш байх ба өргөн 60 см, урт 40 см байх. /эвдэрч хэмхрэхгүй бөх чанарын ширээ байна./
11	Ариутгалын явуулын постны гадна талын рам		Бүхээгны рамыг 5-н квадрат төмөр буюу угольниктэй дүйцэхүйц төмрөөр хийсэн байна. Бүхээгийн дунд хэсгийг 50 см зайтай бэхэлгээ, булангуудад гурвалжин бэхэлгээ хийсэн байна.
12	Чиргүүл/ чирдэг гар		Бүхээгийн хойд, урд талд суурин байрлуулах босоо тулгууртай байна. Тулгуурыг чирж явах үед саад болохооргүй эвхдэг байх Постын бүхээг рүү орох хаалганд шат хийх ба авч болохоор хийгдсэн байх.



Дабрагэ гр. 19032



Тэжка мал



Домоў мал:

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], дор дурдсан [бараа, ажил, үйлчилгээ] [гэрээний нэр ба дугаар]-г [саналын үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр Үнийн санал авах баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Энэ санал нь үнийн санал авах баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [моо] хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид гэрээг хэрэгжүүлэхдээ тухайн орон нутагт үйлдвэрлэгддэг бараа, материал, үзүүлж буй үйлчилгээг заавал худалдан авахаа үүгээр мэдэгдэж байна.

[Бараа, ажил, үйлчилгээ]-ний нэр төрөл	Тодорхойлолт	Тоо [хэмжээ/ширхэг]	Нэгж үнэ	Нийт дүн	[НӨАТ болон бусад албан татвар]	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7
Тендерийн нийт үнэ:						

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, /тамга/:

Албан тушаал,

нэр: Хаяг:

2. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>8</sup>

## ЗАХИАЛАГЧ

## ГҮЙЦЭТГЭГЧ

---

 (Тамга, тэмдэг)

---

 [Тамга, тэмдэг]

---

 (Гарынүсэг)

---

 (Гарын үсэг)

---

 (Албан тушаал)

---

 (Албан тушаал)
**[гэрээний нэр] гэрээ**

Дугаар № [гэрээний дугаар]

 ..... аймаг/хот,  
 ..... сум/дүүрэг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэр, хаяг] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараахь зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ - ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу олон нийтийн оролцоотойгоор бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “гэрээний үүрэг” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцад гарсан зөрчил, гологдлыг бүрэн арилгаагүй нь төлбөр хийхээс татгалзах үндэслэл болно.

4. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэг болох \_\_\_\_\_ **[бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, зөвлөх үйлчилгээ]**-г \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -с \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор гүйцэтгэнэ.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2 Бусад шаардлагатай баримт бичиг<sup>9</sup>;
- 5.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6 Ажлын Зураг, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт;
- 5.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь;
- 5.8 Санхүүжилтийн хуваарь;

---

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдолыг гарсан даруй арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажил болон зөрчил, гологдол гарсан даруй арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор<sup>10</sup> харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Гүйцэтгэгчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

---

### 3. ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙН МАЯГТ

Жишиг маягт

МАЯГТ (3.1)

#### Ерөнхий мэдээлэл

Тендерт оролцогч (туслан гүйцэтгэгч гишүүн бүрийг оролцуулан) энэ маягтыг бөглөн ирүүлэх шаардлагатай.

1.	Ахлагчийн нэр	
2.	Хаяг	
3.	Утас	Цахим шуудан
4.	Факс	Телекс
5.	<i>[Бүртгэгдсэн, нэгдэн нийлсэн газар]</i>	<i>[Бүртгэгдсэн, нэгдэн нийлсэн огноо]</i>

Туслан гүйцэтгэгч гишүүд	
Иргэний нэр	
1.	
2.	
3.	
4.	
5.	

Энэхүү мэдээллийг тендерт оролцогч (ахлагч, туслан гүйцэтгэгч гишүүн бүрийг оролцуулан) бөглөн ирүүлнэ.

МАЯГТ (3.2)

**Ажлын туршлагын ерөнхий мэдээлэл**

Тендерт оролцогчийн нэр

Энэхүү мэдээллийг тендерт оролцогч (ахлагч болон бүлгийн гишүүн бүрийг оролцуулан)-ийн хийж гүйцэтгэсэн ижил төсөөтэй ажлын туршлагын талаар бөглөн ирүүлнэ.

Гэрээний нэр, товч тодорхойлолт	
Уг гэрээний захиалагч байгууллагын тухай	
Улс, Хотын нэр	
Тухайн гэрээнд гүйцэтгэсэн үүрэг, оролцсон оролцооны хувь хэмжээ (түншлэлийн гишүүд, туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан)	
Тухайн гэрээнд гүйцэтгэсэн үүрэг, оролцсон оролцооны хэмжээний талаар дэлгэрэнгүй тодорхойлолт	
Гэрээ гүйцэтгэж эхэлсэн огноо	
Гэрээ дуусгавар болсон огноо	
Гэрээний дүн (төгрөг)	
Захиалагчийн харилцах хүний нэр	
Хаяг: Утас: Факс:	



МАЯГТ (3.3)

**Ажиллах хүчний чадавхи**

Тендерт оролцогчийн нэр:

Тендерт оролцогч нь гэрээг хэрэгжүүлэхээр санал болгож буй ажиллагсдыг томилж, уг ажиллагсдын туршлагын талаар холбогдох мэдээллийг Маягт (3.4А)-ын дагуу тус тусад нь бөглөн ирүүлнэ. Удирдлага болон хэрэгжилтийн зохион байгуулалттай холбоотойгоор хоёр буюу түүнээс дээш тооны ажилтанг нэг албан тушаалд нэр дэвшүүлж болно.

1.	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр
2.	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр
3.	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр
4.	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр
5.	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр
6.	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр
7. ...	Албан тушаал*
	Санал болгож буй ажилтны нэр

\* ТООЗ-д заасны дагуу

МАЯГТ (3.3А)

**Санал болгож буй ажилтны туршлагын талаар товч мэдээлэл**

Албан тушаал		
Нэр дэвшигчийн мэдээлэл	Нэр	Төрсөн огноо
	Мэргэжлийн байдал	
	Боловсролын байдал	
Одоогийн ажил олгогч	Ажил олгогчийн нэр	
	Ажил олгогчийн хаяг	
	Утас	Холбоо барих (ажилтан, менежерийн нэр)
	Факс	Цахим шуудан (email)
	Нэр дэвшигчийн ажил үүргийн тухай товч	Одоогийн ажил олгогчтой хэд дэх жилдээ ажиллаж байгаа

Сүүлийн **[3]** хүртэлх жилийн мэргэжлийн туршлагын талаар мэдээллийн он цагийн дарааллаар нь нэгтгэн бичнэ. Төсөл тус бүрт холбогдох техникийн болон удирдлагын туршлагын мэдээллийг сайтар тодорхойлно уу.

Эхлэн	Хүртэл	Компанийн нэр/Төслийн нэр/Албан тушаал/Холбогдох техникийн болон удирдлагын туршлагын талаар

## **ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ ЖИШИГ МАЯГТ**

### **Хамтран ажиллах гэрээний жишиг маягтыг бөглөх санамж**

Энэхүү жишиг гэрээний маягт нь зөвхөн Сангийн сайдын 2013 оны ... дугаар сарын ... –ны өдрийн ... дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хамтран ажиллах гэрээг байгуулахад зөвлөмж өгөх зорилго болно.

Энэхүү жишиг гэрээний маягтын ерөнхий зүйл заалтыг өөрчлөхгүйгээр зөвхөн нэмэлт оруулж ашиглахыг зөвлөж байна.

## ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

\_\_\_\_\_хот  
/аймаг, сум, дүүрэг/

№\_

20 .... оны .... дугаар  
сарын .... -ны өдөр

Нэг талаас .....  
.....  
ахлагч /цаашид “Ахлагч” гэх/ нөгөө талаас .....  
.....  
.....  
.. гишүүд (гэх мэт бүлгийн бүх гишүүдийн нэрсийг жагсаан бичнэ) /цаашид “Гишүүд” гэх/  
/хамтад нь “Иргэдийн бүлэг” гэх/ бид дараахь нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү  
гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Иргэдийн бүлэг нь .....  
..... /захиалагчийн нэр/ зарласан олон  
нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд оролцож, гэрээ гүйцэтгэхээр хамтран  
ажиллана.
- 1.2. Иргэдийн бүлгийн ахлагч нь ..... овогтой .....  
..... /Регистрийн дугаар, хаяг/ нь байна.
- 1.3. Иргэдийн бүлгийн гишүүд нь
  - 1.3.1. .... овогтой ..... /Регистрийн  
дугаар, хаяг/ нь байна.
  - 1.3.2. .... овогтой ..... /Регистрийн  
дугаар, хаяг/ нь байна.
  - 1.3.3. .... овогтой ..... /Регистрийн  
дугаар, хаяг/ нь байна. (гэх мэт)
- 1.4. Гэрээний хугацаа нь ..... байна. Гэрээний хугацааг талууд  
тохиролцон сунгаж болно.

### ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГА, ХЯНАЛТ

- 2.1. Энэхүү гэрээний 1.1.-д заасан чиглэл хэлбэрийн хамтын ажиллагаатай холбоотой  
үйл ажиллагааг Ахлагч нь дангаар төлөөлөн, удирдан явуулна.
- 2.2. Ахлагч нь хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хөрөнгө мөнгөний зарцуулалтыг  
\_бүрийн хугацаанд тогтмол тайлагнах үүрэгтэй.
- 2.3. Гэрээний аль ч тал гэрээний хэрэгжилт, бусад талуудын гэрээний талаархи үйл  
ажиллагаанд хяналт тавих эрхтэй.
- 2.4. Гэрээний аль нэг тал бусад талын шаардсан үед хамтын ажиллагаатай холбоотой  
өөрийн хийсэн ажлын талаар тайлан тавих үүрэгтэй.

### ГУРАВ. ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 3.1. Иргэдийн бүлэг нь ..... (бараа, ажил, үйлчилгээ)  
захиалагчтай байгуулсан гэрээнд заасан нөхцөлийн дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

- 3.2. Ахлагч нь бүлгийн төлөөлөх эрхтэй бөгөөд захиалагчтай шууд харилцана.
- 3.3. Ахлагч нь захиалагчаас иргэдийн бүлгийн нэрийн өмнөөс захиалагчаас зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийх эрхтэй.
- 3.4. Хамтын үйл ажиллагааны үр дүн, алдагдал хохирол, бусад этгээдийн өмнө үүссэн харуицлагыг талууд дараахь зарчмаар хариуцна:  
 Хамтран хариуцах:  
 1.  
 2.  
 3.  
 4.  
 5. .... /жагсаан бичнэ/<sup>11</sup>  
 Тус тусдаа хариуцах:  
 1.  
 2.  
 3.  
 4.  
 5. .... /жагсаан бичнэ/<sup>12</sup>
- 3.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй үед нөгөө талдаа дараахь торгууль эсхүл алданги төлнө.  
 /дараахь хувилбарын аль нэгийг сонгож болно/  
 - үүргийн үнийн дүнгийн \_\_хувийн торгууль төлнө.  
 - үүргийн гүйцэтгэлийн хожимдуулсан хоног тутам \_\_хувийн / 0,5-аас ихгүй байх/ алданги төлнө.

#### **ДӨРӨВ. БУСАД ЗААЛТ**

- 5.2. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 5.3. Хамтын үйл ажиллагааны тайланг талууд жил тутам, явцын тухай шаардлагатай тохиолдолд хэлэлцэж байна.
- 5.4. Талуудын хооронд маргаан үүссэн тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **ТАВ. ТАЛУУДЫН ХАЯГ**

---

АХЛАГЧ:

Хаяг:  
Утас:  
Цахим шуудангийн хаяг:

Гарын үсэг:

ГИШҮҮД:

Хаяг:  
Утас:  
Цахим шуудангийн хаяг:

Гарын үсэг: